ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2023/118/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өвөрхангай аймаг,<br>Арвайхээр сум<br>2023 он | Тэргүүлэх аудитор: О.Батжаргал<br>Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Гансүх<br>Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com<br>Аудитор: Р.Энхзул<br>Утас: 70323108 Цахим хаяг: Enkhzulr@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........................................

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин........................................

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........................

4. Аудитын тайлан ........................................

4.1 Ерөнхий зүйл ........................................

4.2 Материаллаг байдал ........................................

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........................................

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................

5. Аудитын илрүүлэлт ........................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023. 02. 13 № 55
танай ____________-ны №____________-т

БҮРД СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.УРАНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Тайлант онд боловсролын байгууллагууд гүйцэтгэлээр санхүүждэг болсон бөгөөд тус байгууллага нь 2022 онд улсын төсвөөс 244,213.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 27,712.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 687,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд 250,589.0 мянган төгрөгийг зарцуулж, 22,025.0 мянган төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг нэр төрөл бүрээр тоолоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооллого хангалтгүй хийсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

015030330
D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 45,917,664.60 | 58,619,615.05 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 22,025,021.45 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 22,025,021.45 |
| 3121 | Төгрөг | - | 22,025,021.45 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 21,422,973.45 |
| 31217 | Төрийн сангийн харилцах-Орон нутаг | | 602,048.00 |
| 33 | АВЛАГА | 933,920.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 933,920.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 44,983,744.60 | 36,594,593.60 |
| 354 | Хангамжийн материал | 44,983,744.60 | 36,594,593.60 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,551,235.60 | 30,060,635.60 |
| 35460 | Хүнсний материал | 22,432,509.00 | 6,533,958.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 449,355,611.49 | 320,825,381.22 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 449,355,611.49 | 320,825,381.22 |
| 392 | Биет хөрөнгө | 445,355,611.49 | 315,925,381.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 457,429,868.07 | 327,309,459.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (24,659,465.00) | (20,622,509.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 22,138,058.00 | 15,170,458.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (13,230,216.68) | (7,265,462.80) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,873,773.00 | 8,564,094.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,114,337.40) | (8,000,658.12) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,147,931.00 | - |
| 39217 | Ном | 770,000.50 | 770,000.50 |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,000,000.00 | 4,900,000.00 |
| 39301 | Програм хангамж | - | 900,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 495,273,276.09 | 379,444,996.27 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 1,099,021.12 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 1,099,021.12 |
| 413 | Өглөг | - | 1,099,021.12 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 199,021.12 |
| 4136 | Бусад өглөг | - | 900,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 900,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 495,273,276.09 | 378,345,975.15 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 495,273,276.09 | 378,345,975.15 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 377,902,289.10 | 377,902,289.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 377,902,289.10 | 377,902,289.10 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (45,733,227.27) | (162,660,528.21) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (42,815,709.43) | (45,733,227.27) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (2,917,517.84) | (116,927,300.94) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 163,104,214.26 | 163,104,214.26 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 495,273,276.09 | 379,444,996.27 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **235,734,902.00** | **292,697,512.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,829,458.00** | **20,083,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,829,458.00 | 20,083,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,829,458.00 | 20,083,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,829,458.00 | 20,083,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **230,905,444.00** | **272,614,012.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 229,283,712.00 | 244,901,412.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 244,213,600.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 229,283,712.00 | 687,812.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 27,712,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 27,712,600.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 687,812.00 | - |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 687,812.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 933,920.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 933,920.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **237,030,687.83** | **267,697,960.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **237,030,687.83** | **267,697,960.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 232,963,048.26 | 256,309,460.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 156,019,696.00 | 168,658,942.55 |
| 210101 | Үндсэн цалин | 98,873,748.00 | 116,135,343.64 |
| 210102 | Нэмэгдэл | 46,955,728.00 | 36,322,250.96 |
| 210104 | Урамшуулал | 10,190,220.00 | 11,016,837.95 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 5,184,510.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,546,422.42 | 21,472,789.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,624,022.64 | 15,442,782.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,480,600.24 | 1,486,208.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,184,499.98 | 1,161,444.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 296,100.02 | 430,220.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,961,199.54 | 2,952,132.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,550,083.00 | 14,647,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,243,907.00 | 1,660,203.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,836,176.00 | 12,517,097.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 470,000.00 | 470,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,834,845.00 | 4,235,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 203,600.00 | 2,283,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,299,800.00 | 1,365,780.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,444,300.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 887,145.00 | 586,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,412,355.00 | 35,587,051.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,900.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 27,119,355.00 | 35,587,051.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 251,100.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 104,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 104,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 391,000.00 | 444,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 444,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,104,046.84 | 10,263,797.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 131,800.00 | 2,760,420.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 829,300.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,142,946.84 | 7,503,377.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,067,639.57 | 11,388,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 11,388,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 11,388,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,067,639.57 | - |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 99,000.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,968,639.57 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,295,785.83)** | **24,999,551.45** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 141,926,852.39 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 141,926,852.39 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (141,926,852.39) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,295,785.83)** | **(116,927,300.94)** |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **229,283,712.00** | **272,614,012.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **229,283,712.00** | **272,614,012.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 229,283,712.00 | 244,901,412.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 244,213,600.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 687,812.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 212,687,200.00 | - |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 15,908,700.00 | - |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | - | 687,812.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 27,712,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 27,712,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **229,283,712.00** | **250,588,990.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **229,283,712.00** | **250,588,990.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **225,216,072.43** | **239,200,490.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157,831,800.00 | 168,459,921.43 |
| 210101 | Үндсэн цалин | 100,685,852.00 | 115,936,322.52 |
| 210102 | Нэмэгдэл | 46,955,728.00 | 36,322,250.96 |
| 210104 | Урамшуулал | 10,190,220.00 | 11,016,837.95 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 5,184,510.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,788,199.43 | 20,538,869.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,865,799.64 | 14,508,862.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,480,600.25 | 1,486,208.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,184,499.98 | 1,161,444.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 296,100.02 | 430,220.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,961,199.54 | 2,952,132.43 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,550,083.00 | 14,647,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,243,907.00 | 1,660,203.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,836,176.00 | 12,517,097.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 470,000.00 | 470,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,937,345.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 203,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,299,800.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,444,300.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 102,500.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 887,145.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 26,651,945.00 | 19,688,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,900.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 26,358,945.00 | 19,688,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 251,100.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 104,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 104,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний** | 391,000.00 | 444,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 444,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 67,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 961,100.00 | 14,421,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 131,800.00 | 12,171,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 829,300.00 | 2,250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,067,639.57** | **11,388,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 99,000.00 | 11,388,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 99,000.00 | 11,388,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,968,639.57 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,968,639.57 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **22,025,021.45** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 22,025,021.45 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 22,025,021.45 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 377,902,289.10 | 0.00 | -45,733,227.27 | 163,104,214.26 | 495,273,276.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **377,902,289.10** | **0.00** | **-45,733,227.27** | **163,104,214.26** | 495,273,276.09 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -116,927,300.94 | 0.00 | -116,927,300.94 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **377,902,289.10** | **0.00** | **-162,660,528.21** | **163,104,214.26** | 378,345,975.15 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 244,213,600.00 | 223,478,438.55 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 244,213,600.00 | 223,478,438.55 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 232,825,100.00 | 212,089,938.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 160,736,200.00 | 158,270,363.43 |
| 210101 | Үндсэн цалин | 125,008,600.00 | 110,931,274.52 |
| 210102 | Нэмэгдэл | 29,984,600.00 | 36,322,250.96 |
| 210104 | Урамшуулал | 5,743,000.00 | 11,016,837.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,705,000.00 | 19,265,175.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,119,600.00 | 13,721,147.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,896,300.00 | 1,364,463.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,517,100.00 | 1,064,170.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 379,200.00 | 405,752.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,792,800.00 | 2,709,642.01 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,518,000.00 | 19,688,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,518,000.00 | 19,688,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 444,000.00 | 444,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 444,000.00 | 444,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,421,900.00 | 14,421,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,171,900.00 | 12,171,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,250,000.00 | 2,250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11,388,500.00 | 11,388,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,388,500.00 | 11,388,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,388,500.00 | 11,388,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 244,901,412.00 | - |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 244,213,600.00 | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 244,213,600.00 | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 687,812.00 | - |
| 132004 | Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/ | 687,812.00 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 21,422,973.45 |

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэмэлт тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,712,600.00** | **27,110,552.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,712,600.00** | **27,110,552.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 27,712,600.00 | 27,110,552.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 10,791,600.00 | 10,189,558.00 |
| 210101 | Үндсэн цалин | 10,791,600.00 | 5,005,048.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 5,184,510.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,273,700.00 | 1,273,694.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 787,600.00 | 787,715.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 121,800.00 | 121,745.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 97,300.00 | 97,274.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 24,500.00 | 24,468.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 242,500.00 | 242,490.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 14,647,300.00 | 14,647,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,505,300.00 | 1,660,203.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,672,000.00 | 12,517,097.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 470,000.00 | 470,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **602,048.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 602,048.00 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрд сумын Цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, багш бүр хичээл сургалтын бэлтгэлийг чанартай бэлтгэж, суралцагчийн хөгжил төлөвшилд ахиц гаргах, эцэг эх асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, багш бүр мэргэжлээрээ хөгжих боломж бүрдүүлэн ажиллах” зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 22,025.0 | 22025.0 |
| Авлага | 933.9 | 0 | -933.9 |
| Бараа материал | 44,983.8 | 36,594.6 | -8,389.2 |
| Үндсэн хөрөнгө | 449,355.6 | 320,825.4 | -128,530.2 |
| **Нийт хөрөнгө** | **495,273.3** | **379,445.0** | **-115,828.3** |
| Өр төлбөр | 0 | 1099.0 | 1099.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **495,273.3** | **378,346.0** | **-116,927.3** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **495,273.3** | **379,445.0** | **-115,828.3** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс өссөн нь боловсролын байгууллагууд гүйцэтгэлээр санхүүждэгээс шалтгаалан төвлөрүүлэлт хийхгүй харилцахын үлдэгдэлтэй гарсантай холбоотой. Үндсэн хөрөнгө буурсан нь *150.1 сая төгрөгийн цэцэрлэгийн хуучин барилгыг шилжүүлж, 11.4 сая төгрөгийн хөрөнгө акталж, 20.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, 0.9 сая төгрөгийн программ хангамж нэмэгдсэнтэй холбоотой байна. Өр төлбөр нэмэгдсэн нь худалдан авсан 0.9 сая төгрөгийн санхүүгийн программ, 0.2 сая төгрөгийн НДШ-ийн өртэй холбоотой байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 228.8 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

*Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 244.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 27.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.*

*Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 250.6 сая төгрөг, 22.0 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.*

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс, нэмэгдэл урамшил | 160,736.2 | 158,270.4 | 2,465.8 | 98.5 |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,705.0 | 19,265.2 | 4,439.8 | 81.3 |
| 3 | Нормативт зардал | 33,518.0 | 19,688.5 | 13,829.5 | 58.7 |
| 4 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 444.0 | 444.0 | 0 | 100.0 |
| 5 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,421.9 | 14,421.9 | 0 | 100.0 |
| 6 | Урсгал шилжүүлэг | 11,388.5 | 11,388.5 | 0 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс, нэмэгдэл урамшил | 10,791.6 | 10,189.6 | 602.0 | 94.4 |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,273.7 | 1,273.7 | 0 | 100.0 |
| 3 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,647.3 | 14.647.3 | 0 | 100.0 |
| 4 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000.0 | 1,000.0 | 0 | 100.0 |

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бүрд сумын Цэцэрлэгийн 2022 оны 2 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2023.01.11-нээс 2023.02.13–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2023.02.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Р.Энхзул хариуцан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2023.01.10-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 80 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 267.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль *хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.*

*Энэ хуулийн хүрээнд хэмнэсэн зардал байхгүй, зөрчил илрээгүй.*

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай гэж үнэлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын хувьд 2022 онд завсрын аудитаар дараах зөрчил илэрсэн.

| Д/д | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|
| 1 | Бараа материалын тайлан | Шатахууны тайлангийн анхан шатны баримт дутуу, жолоочийн тооцоо хийгээгүй | 1,043.1 | Зөвлөмж |
| 2 | Хоолны зардал | Хүүхдийн хоолны зардлыг нормативт зардлаас хэтрүүлэн зарцуулсан | 1,784.7 | Зөвлөмж |
| 3 | Хөрөнгийн зардал | Үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогыг нэр төрөл нь тоолоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооллого хангалтгүй хийсэн байна. | 533,937.0 | Зөвлөмж |
| 4 | Шилэн данс | Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтын мэдээллийг дутуу мэдээлсэн | 99,372.0 | Зөвлөмж |

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар 22.4 сая төгрөгийн зөрчил илэрч цаашид алдаа зөрчил арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж бичигдсэн .*

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 1 | 22,432.5 | 1 | 22,432.5 | 100 |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **22,432.5** | **2** | **22,432.5** | **100** |

Өмнөх аудитаар бараа материалын тайланд сүүлийн 3 жил дараалан тайлагнасан хүнсний материалын үлдэгдэл бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй, уг үлдэгдлийг шийдвэрлэх талаар тооллогын комиссоос ямар нэг санал гаргаагүй, ашиглаж буй санхүүгийн программ нь нягтлан бодох бүртгэлийн шаардлага хангахгүй байгаагаас дансны журнал, тайлангууд нь зохих түвшинд бэлтгэгдэхгүй гэсэн алдаа зөрчлүүд гарсан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг нэр төрөл бүрээр тоолж, тооллогын анхан шатны баримтын бүрдэл болон тооллогыг чанартай явуулах талаар авч үзэх. Мөн махны үлдэгдлийг анхаарах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар эд хөрөнгийн тооллоготой холбоотой зөрчил[1] илэрч албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр төлбөрийн акт гараагүй.

### 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт:*

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг нэр төрөл бүрээр тоолоогүй, тооллогын анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооллогыг хангалтгүй хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13.7."анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг чанартай явуулж,_биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эд хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар зөрчил илрээгүй.**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр